



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар

44

Улаанбаатар хот

“Дипломат байгууллагын үйлчилгээг
эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн
газрын дүрэмд өөрчлөлт оруулах,
зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын
жагсаалт, орон тооны дээд хязгаарыг
шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 83 дугаар тогтоолоор баталсан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчилсүгэй:

1./Дүрмийн 1.1 дэх заалт:

“1.1.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газар (цаашид “Үйлдвэрийн газар” гэх) нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар (цаашид “дипломат байгууллага” гэх)-ын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад шаардлагатай нийтлэг үйлчилгээг үзүүлэх, гадаад улс дахь дипломат төлөөлөгчийн газрын барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэх, өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах төрийн өмчит аж ахуйн тооцоотой хуулийн этгээд мөн”.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 83 дугаар тогтоолоор баталсан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 3.2-т дор дурдсан агуулга бүхий 3.2.8, 3.2.9 дэх заалтыг тус тус нэмсүгэй:

2.1/Дүрмийн 3.2.8 дахь заалт:

“3.2.8.Гадаад улс дахь Монгол Улсын Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газрын барилга байгууламжийн ашиглалтыг хариуцаж, бүрэн бүтэн байдлыг хангах талаар зохих арга хэмжээ авах, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үзлэг хийх, санал дүгнэлт боловсруулж эрх бүхий байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэх.”

2.2/Дүрмийн 3.2.9 дэх заалт:

“3.2.9.Үл хөдлөх хөрөнгийг дипломат статустай болон дипломат статусгүй этгээдэд эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр, гэрээний үндсэн дээр түрээслүүлэх.”

3.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

3.1.Захиргааны хэлтэс (үл хөдлөх хөрөнгө ашиглалт, маркетингийн албатай);

3.2.Санхүү, эдийн засгийн хэлтэс;

3.3.Үйлчилгээ, ашиглалтын хэлтэс (автобааз, тохижилт, үйлчилгээний алба, зоог, катерингийн алба, засвар үйлчилгээний албатай).

4.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 157 байхаар тогтоосугай.

5.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг 1 дүгээр, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.


6.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны дээд хязгаар батлах тухай” 83 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7.Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд зохих журмын дагуу бүртгүүлэхийг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ё.Нямжавт даалгасугай.

8.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА




Б.ГАНБАТ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 1 дүгээр сарын 14 ны өдрийн
47 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

“ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн
4-р дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**"ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

№	Албан тушаал	Орон тоо
1	Захирал	1
2	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	1
3	Үйлчилгээ, чанар хариуцсан дэд захирал	1
4	Дотоод аудитор	1
Нийт		4
1. Захиргааны хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Хуулийн зөвлөх бөгөөд ахлах мэргэжилтэн	1
3	Хүний нөөц, нийгмийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн	1
4	Хуульч	1
5	Нарийн бичиг, офисс төлөвлөлтийн мэргэжилтэн	1
6	Худалдан авалт, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	1
7	Мэдээлэл технологийн мэргэжилтэн	1
8	Архив, бичиг хэргийн мэргэжилтэн	1
Нийт		8
1.1.Үл хөдлөх хөрөнгө ашиглалт, маркетингийн алба		
1	Албаны дарга	1
2	Маркетингийн менежер	1
3	Ханддоржийн өргөөний зохион байгуулагч-менежер	1
4	Зочид буудлын зохион байгуулагч-менежер	1
5	Зочид буудлын ресепшн	3
6	Угтагч-зохион байгуулагч	1
7	Аж ахуй эрхлэгч	1
8	Касс-нярав	2
Нийт		11
1.2. Харуул, хамгаалалтын алба		
1	Албаны дарга	1
2	Харуул	20
Нийт		21
2. Санхүү, эдийн засгийн хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Ерөнхий нягтлан бодогч	1
3	Эдийн засагч	1
4	Мөнгөн хөрөнгө, харилцах, тайлан хариуцсан нягтлан бодогч	1
5	Үндсэн хөрөнгө, цалин хариуцсан нягтлан бодогч	1
6	Нярав	2
7	Төсөвчин	1
8	Хангамжийн мэргэжилтэн	1
Нийт		9
3. Үйлчилгээ, ашиглалтын хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Хяналтын ерөнхий инженер буюу ахлах мэргэжилтэн	1
3	Эрүүл ахуйч-эмч	1
4	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэргэжилтэн	1
Нийт		4
3.1. Автобаазын алба		
1	Албаны дарга	1
2	Механикч	1
3	Диспетчир	1
4	Нярав-жолооч	1
5	Засварчин	1

5	Жолооч	39
Нийт		44
3.2. Зоог, катерингийн алба		
1	Албаны дарга	1
2	Нярав-касс	1
3	Ахлах тогооч	1
4	Тогооч	4
5	Туслах тогооч	2
6	Ахлах-визитийн үйлчлэгч	1
7	Визитийн үйлчлэгч	5
8	Туслах ажилтан	2
Нийт		17
3.3. Засвар, үйлчилгээний алба		
1	Албаны дарга	1
2	Техникч	1
3	Сантехникийн слесарь	4
4	Цахилгаанчин	2
6	Барилгын засалчин	6
Нийт		14
3.4. Тохижолт, үйлчилгээний алба		
1	Албаны дарга	1
2	Үйлчлэгч	21
3	Гадаа талбайн үйлчлэгч	2
4	Ачигч	1
Нийт		25
БҮГД		157